



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/073/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Долгорсүрэн Утас: 261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn Ахлах аудитор: С.Отгонхорлоо Утас: 261205 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эс Жи Эм Ди -Аудит ХХК Захирал: Д.Эхбаяр Утас: 99116948 Цахим хаяг: ekhbayar@sgmd-audit.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ К.ЭРДЭНЭБАЯР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.17 № 07/1090
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эрчим хүчний зохицуулах хорооноос цахилгаан түгээлтийн алдагдлыг 12.20 хувиар баталсныг тус компани 10.54 хувь хүртэл бууруулж, тайлант онд түгээлтийн алдагдлыг бууруулснаас бүрдүүлсэн 14,500.0 сая төгрөгийн орлогыг хөрөнгө оруулалтын өгөөж хэлбэрээр тарифт тусган, ухаалаг тоолуурын систем нэвтрүүлэх төслийн эхний үе шатыг хэрэгжүүлсэн байна. Төслийн хүрээнд цахилгаан түгээлтийн алдагдал өндөртэй Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн хэрэглэгчдэд үйлчлэх төвүүд болон Зуунмод төвийн нийт 130.0 мянган хэрэглэгчид ухаалаг тоолуур суурилуулах эхний үе шатыг амжилттай хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Цахилгаан эрчмийн алдагдлыг төлөвлөснөөс 1.45 пунктээр бууруулснаар борлуулсан цахилгаан эрчим хүч 68.0 сая кВтц буюу 1.9 хувиар өссөн байна. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр цахилгаан эрчим хүчний алдагдлыг 10.50 хувьд хүргэж, өмнөх оны мөн үеэс 1.2 пунктээр бууруулжээ.

Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолоор баталсан “Гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”-ын дагуу гэр хорооллын хэрэглэгчдэд 20,564.4 сая төгрөгийн шөнийн тарифын хөнгөлөлт үзүүлж, уг хөнгөлөлтөд шаардлагатай эх үүсвэрийг улсын төсвөөс бүрэн санхүүжүүлсэн байна. Мөн өмнөх оны шөнийн тарифын хөнгөлөлтийн хуримтлагдсан өр төлбөр 6,206.8 сая төгрөгийг улсын төсвөөс төлж барагдуулжээ.

Бусад асуудал

Их засвар, техник зохион байгуулалтын ажлын хүрээнд 51,262.4 сая төгрөгийн хөрөнгийг шинээр бүртгэлд авснаас 14,050.4 сая төгрөг нь хөрөнгө оруулалтын өгөөж буюу Ухаалаг тоолуур төслийн хөрөнгө байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,981,975,970.97	7,342,127,439.71
1.1.2	Дансны авлага	48,289,843,581.23	54,336,663,365.74
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	695,357,958.60	1,772,907,632.41
1.1.4	Бусад авлага	2,043,564,300.66	1,309,294,519.84
1.1.6	Бараа материал	12,349,434,327.55	13,495,382,378.49
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	47,819,822.80	27,329,397.64
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	66,407,995,961.81	78,283,704,733.83
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	343,583,589,542.91	360,494,468,619.76
1.2.2	Биет бус хөрөнгө	4,100,912,011.31	4,605,921,923.16
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	375,655,456.24	317,862,309.13
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	348,060,157,010.46	365,418,252,852.05
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	414,468,152,972.27	443,701,957,585.88
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	32,228,102,681.77	57,000,841,282.11
2.1.1.2	Цалингийн өглөг	4,896,926,712.82	7,183,085,397.71
2.1.1.3	Татварын өр	2,097,578,611.02	5,581,279,085.95
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	14,002,154.45
2.1.1.5	Богино хугацаат зээл	3,312,761,541.11	2,354,388,007.27
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,986,744,426.54	2,026,632,752.43
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	759,847,263.19	454,123,200.95
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	45,281,961,236.45	74,614,351,880.87
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	21,453,878,720.16	19,099,490,712.89
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	4,816,208,063.94	5,066,231,619.48
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	49,153,061,439.19	45,858,386,731.17
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	75,423,148,223.29	70,024,109,063.54
2.2	Өр төлбөрийн нийт дүн	120,705,109,459.74	144,638,460,944.41
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	239,360,638,644.76	247,079,143,164.82
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	40,954,606,964.40	40,064,941,872.37
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	10,209,210,443.49	6,572,308,536.48
2.3.9	Хуримтлагдсан ашиг	3,238,587,459.88	5,347,103,067.80
2.3.11	Эздийн өмчийн дүн	293,763,043,512.53	299,063,496,641.47
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	414,468,152,972.27	443,701,957,585.88

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	744,542,411,040.28	844,168,466,635.46
	ЦЭХ-ний орлого	646,272,154,440.28	721,348,935,008.18
	Түгээх үйлчилгээний орлого	98,270,256,600.00	122,819,531,627.28
2	Борлуулалтын өртөг	697,851,857,863.00	780,137,887,867.21
	ХАЦЭХ	638,430,445,427.52	708,594,520,743.65
	Түгээх үйл ажиллагааны зардал	59,421,412,435.48	71,543,367,123.58
3	Нийт ашиг (алдагдал)	46,690,553,177.28	64,030,578,768.25
4	Түрээсийн орлого	77,697,955.05	120,772,836.36
5	Хүүний орлого	12,045,280.26	1,411,614,077.65
8	Бусад орлого	19,086,478,623.41	21,557,378,146.09
9	Борлуулалт, маркетингийн зардал	36,084,534,001.29	45,736,125,068.96
10	Ерөнхий ба удирдлагын зардал	16,395,159,063.43	20,971,597,110.88
11	Санхүүгийн зардал	498,616,660.77	370,596,741.62
12	Бусад зардал	11,755,061,085.10	18,249,925,089.60
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(717,401,250.17)	24,159,973.64
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	416,002,975.24	1,816,259,790.93
19	Орлогын татварын зардал	410,746,320.50	552,632,491.44
20	Татварын дараах ашиг (алдагдал)	5,256,654.74	1,263,627,299.49

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сары 31-ний үлдэгдэл	210,661,703,243.86	42,131,594,700.88	32,934,311,024.09	2,546,641,210.94	288,274,250,179.77
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	686,689,594.20	686,689,594.20
3	Залруулсан үлдэгдэл	210,661,703,243.86	42,131,594,700.88	32,934,311,024.09	3,233,330,805.14	288,960,939,773.97
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	5,256,654.74	5,256,654.74
6	Өмчид гарсан өөрчлөлт	28,698,935,400.90	-	(22,725,100,580.60)	-	5,973,834,820.30
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(1,176,987,736.48)	-	-	(1,176,987,736.48)
9	2023 оны 12-р сары 31-ний үлдэгдэл	239,360,638,644.76	40,954,606,964.40	10,209,210,443.49	3,238,587,459.88	293,763,043,512.53
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	847,516,635.80	847,516,635.80
11	Залруулсан үлдэгдэл	239,360,638,644.76	40,954,606,964.40	10,209,210,443.49	4,086,104,095.68	294,610,560,148.33
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,263,627,299.49	1,263,627,299.49
14	Өмчид гарсан өөрчлөлт	7,718,504,520.06	-	(3,636,901,907.01)	-	4,081,602,613.05
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	(2,628,327.37)	(2,628,327.37)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(889,665,092.03)	-	-	(889,665,092.03)
17	2024 оны 12-р сары 31-ний үлдэгдэл	247,079,143,164.82	40,064,941,872.37	6,572,308,536.48	5,347,103,067.80	299,063,496,641.47

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	785,028,055,276.41	955,161,424,664.03
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	675,359,471,780.43	737,751,666,924.64
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	274,402,700.33	321,583,534.00
	Татаас, санхүүжилтийн орлого	-	148,399,362,217.47
	Бусад мөнгөн орлого	109,394,180,795.65	68,688,811,987.92
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	775,035,298,341.02	941,209,216,320.77
	Ажиллагчдад төлсөн	50,498,921,024.78	64,033,757,719.36
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	15,543,162,198.41	20,313,702,786.19
	Бараа материал худалдан авахад төлсөн	19,390,272,888.23	33,363,828,074.88
	Ашиглалтын зардалд төлсөн	2,157,806,464.65	2,681,237,831.42
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,439,105,798.92	3,153,226,356.12
	Хүүний төлбөрт төлсөн	504,034,821.69	462,913,729.01
	Татварын байгууллагад төлсөн	14,427,041,892.65	13,934,720,254.20
	Даатгалын төлбөрт төлсөн	97,672,062.00	115,995,943.00
	Бусад мөнгөн зарлага	668,977,281,189.69	803,149,833,626.59
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	9,992,756,935.39	13,952,208,343.26
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	44,392,280.26	702,127,587.83
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	32,347,000.00	23,878,973.64
	Хүлээн авсан хүүний орлого	12,045,280.26	678,248,614.19
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	9,110,236,197.23	7,936,191,744.45
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	9,110,236,197.23	7,936,191,744.45
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(9,065,843,916.97)	(7,234,064,156.62)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,800,000,000.00	
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,800,000,000.00	
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,355,456,621.30	2,357,992,717.90
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,355,456,621.30	2,355,364,390.53
	Төлсөн ногдол ашиг		2,628,327.37
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	444,543,378.70	(2,357,992,717.90)
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,339,109,397.12	4,360,151,468.74
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,642,866,573.85	2,981,975,970.97
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,981,975,970.97	7,342,127,439.71

2.5 Техник, Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 он			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биетээр	хувиар
	А	1	2	3	4	5=4-3	6=4/3
1	Худалдан авах цахилгаан	сая.кВтц	3,850.20	4,034.10	4,044.50	10.40	100
	ЦЭХ-ний алдагдал	хувь	11.7	12.0	10.5	-1.50	88
	биетээр	сая.кВтц	448.40	483.90	426.40	(57.50)	88
	Борлуулах ЦЭХ	сая.кВтц	3,401.70	3,550.20	3,618.20	68.00	102
2	Нийт орлого	сая.төг	763,748.0	804,153.9	867,282.3	63,128.4	108
	ЦЭХ-ийн орлого, түрээс	сая.төг	646,272.2	676,912.7	721,348.9	44,436.2	107
	Түгээх үйл ажиллагааны орлого	сая.төг	98,270.3	110,426.9	122,819.5	12,392.6	111
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	сая.төг	19,205.6	16,814.3	23,113.9	6,299.6	137
3	Нийт зардал, үүнээс	сая.төг	763,332.0	807,763.7	865,466.1	57,702.4	107
	ЦЭХ-ийн төлбөр	сая.төг	638,430.4	663,191.2	708,594.5	45,403.3	107
	Үйл ажиллагааны зардал	сая.төг	112,399.7	129,994.3	138,621.7	8,627.4	107
	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	сая.төг	12,501.9	14,578.2	18,249.9	3,671.7	125
	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	сая.төг	26,582.6	22,600.6	29,924.0	7,323.4	132
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	сая.төг	416.0	(3,609.8)	1,816.2	5,426.0	-50
	Орлогын татвар	сая.төг	410.7		552.6	552.6	
5	Цэвэр ашиг, алдагдал	сая.төг	5.2	(3,609.8)	1,263.6	4,873.4	-35
6	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал		1.0	1.0	1.0	-	100
7	Нийт авлага	сая.төг	51,028.8	58,982.7	57,418.8	(1,563.9)	97
	ЦЭХ-ийн авлага	сая.төг	48,289.8	55,428.9	54,336.6	(1,092.3)	98
	Бусад авлага	сая.төг	2,738.9	3,553.8	30,882.2	27,328.4	869
8	Нийт өр төлбөр	сая.төг	120,705.0	114,321.0	144,638.5	30,317.4	127
	Богино хугацаат өр	сая.төг	45,281.9	38,676.8	74,614.3	35,937.5	193
	Урт хугацаат өр төлбөр	сая.төг	75,423.1	75,644.2	70,024.1	(5,620.1)	93
9	Ажиллагсдын тоо	хүн	1,940.0	1,950.0	1,950.0	-	100
10	Цалингийн сан	сая.төг	51,736.5	67,787.7	68,539.2	751.5	101
11	Цахилгаан тасалдан дундаж хугацаа Исайди	Минут	917.8	803.9	788.5	(15.4)	98

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1. Аудитаар нийт 6,957.2 сая төгрөгийн 3 алдаа¹ илрүүлж, аудитын явцад 6,957.2 сая төгрөгийн 3 алдааг залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ТУЗ-ын 2024 оны 14 дүгээр тогтоолоор хөрөнгийг 7,718.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэхийг дэмжсэн, үүнээс ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр 7,682.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 36.0 сая төгрөгөөр дутуу бүртгэж тайлагнасан.	1	36.0	1	36.0	-	-	1	36.0	-	-	-	-
2023 оны аудитаар залруулсан гүйлгээг буцааж бичсэн тул дахин залруулах шаардлагатай. 2024.12.31 нээрх санхүүгийн тайланд хойшлогдсон татварын өглөгийг 11,899,104,648.08 төгрөгөөр тайлагнасан байна. Тус үлдэгдлийн 6,832,873,028.60 төгрөгөөрх дүнг 2023 онд Юнитакс ТИН ХХК-ийн "Tax Ass 1.0" программ ашиглан шинээр тооцоолсон. Тус программд өгөгдөл болгон оруулсан анхны дүнг тулган баталгаажуулах анхан шатны баримтыг Өмнөх үеийн болон тайлант үеийн аудитад ирүүлээгүй.	1	6,832.9	-	-	1	6,832.9	1	6,832.9	-	-	-	-
Баянзүрх дүүргийн Засаг даргын 2015 оны А/362 дугаар захирамжийг үндэслэн тус дүүргийн 35 дугаар хорооны /хуучнаар 20-р хороо/ нутаг дэвсгэрт байрлах 40158 м.кв газрыг амралт сувиллын зориулалтаар эзэмшдэг. Тус газрыг 2018-12-31-нд 111.2 сая төгрөгөөр үнэлж, бүртгэсэн байна. 2024.08.14 ны өдөр тус газрын	1	88.3	-	-	1	88.3	1	88.3	-	-	-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/, СНАГ-2025/073/НА-СТА-ТӨҮГ

дуудлага худалдааны анхны үнэ 88.3 сая төгрөгийг нөхөн төлж, эзэмшил газрын хэмжээ нэмэгдээгүй байхад газрын эрхийг нэмэгдүүлэн бүртгэсэн.												
Дүн	3	6,957.2	1	36.0	2	6,921.2	3	6,957.2	-	-	-	-

3.2. Аудитаар нийт 5,914.7 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 5,658.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 256.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант хугацаанд Цахилгаан эрчим хүч хэрэглэгч байгууллагаас авах нийт 17,296.4 сая төгрөгийн авлага байгаагаас 4,131.8 сая төгрөг, 409.3 сая төгрөгийн бусад авлагыг төвийн аж ахуйн нэгж, байгууллагатай, 6,119.9 сая төгрөгийн авлагыг Эрчим хүчний яамтай, 230.8 сая төгрөгийн өр төлбөрийг төвийн аж ахуйн нэгж, байгууллагатай тус тус тооцоог нийлж, актаар баталгаажуулаагүй байна.	1	1,566.4	-	-	1	1,566.4	-	-	-	-	-	-
Компанийн автомашинуудын шатахуун зарцуулалтын нормыг албан ёсоор тогтоож, баталгаажуулж мөрдөөгүйгээс тайлант онд шатахууныг жишиг нормоор нь тооцож олгоогүй, гүйцэтгэлийг бүрэн хянаж, тооцоог бодоогүй байна.	1	0.0	-	-	1	0.0	-	-	-	-	-	-

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Ашиглалт засварын баруун төвийн барилгын дотор агааржуулалтын засварын 183.6 сая төгрөгийн ажлын төсвийг эрх бүхий мэргэшсэн төсөвчнөөр хийлгүүлсэн хяналтын төсөв байхгүй, "Оффисын барилгын засвар"-ын 1,329.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын хяналтын зураг, төсвийг эрх бүхий төсөвчнөөр болон магадлалаар баталгаажуулсан гэж үзэх нотлох баримтгүй, худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа цахим системийн ТЭЗҮ хэсэгт техникийн тодорхойлолт, хяналтын зураг төсвийг оруулаагүй, шаардлагатай тусгай зөвшөөрлийн заалтыг заагаагүйгээр тендер шалгаруулалтыг зохион байгуулсан.	1	1,512.6	-	-	1	1,512.6	-	-	-	-	-	-
Тээврийн хэрэгсэл нийлүүлэх тендерийн гэрээг сунган тендерийн өгөгдлийн хүснэгтэд шаардсан хөдөлгүүрийн багтаамжаас бага (жижиг) тээврийн хэрэгслийг нийлүүлснийг хүлээн авсан.	1	78.0	-	-	1	78.0	-	-	-	-	-	-
Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албатай хийсэн "Төв цэнгэлдэх хүрээлэнгийн цахилгаан хангамжийн найдваржилтыг сайжруулах" 2,500.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг тендер шалгаруулахгүйгээр гэрээ шууд байгуулсан байна.	1	2,501.0	-	-	1	2,501.0	-	-	-	-	-	-
НБББББ-т заасны дагуу хоёроос дээш жил ашиглаагүй агуулахад байгаа бараа материалын насжилтыг харгалзан үнийн дүнгээс 5-100 хувиар хасагдуулага тооцон өссөн дүнгээр 1,759.5 сая төгрөгийн бараа материалын хасагдуулгыг бүртгэсэн байна.	1	0.0	-	-	-	-	1	0.0	-	-	-	-
Төрийн мэдээлэл солилцооны "Хур" системд УБЦТС ТӨХК-ийн нэр дээр газар эзэмших эрхийн нийт 74 нэгж талбар бүртгэлтэй байгаагаас тус байгууллагын санхүүгийн тайланд нийт 44 нэгж талбар газар үнэлэгдэж бүртгэгдсэн байна.	1	0.0	-	-	-	-	1	0.0	-	-	-	-
Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын үр дүнг, "Өмч хамгаалах комисс"-ын хурлаар хэлэлцүүлж баталгаажуулаагүй байна.	1	0.0	-	-	-	-	1	0.0	-	-	-	-
Тайлант оны борлуулалтын орлого нь и-баримтын дүнгээс 233.5 сая төгрөгөөр, НӨАТ-ын өглөг 23.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албатай хийсэн "Төв цэнгэлдэх хүрээлэнгийн цахилгаан хангамжийн найдваржилтыг	1	256.7	-	-	-	-	1	256.7	-	-	-	-

сайжруулах" ажлын гэрээний дүн 2,500.9 сая төгрөгөөр борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэхдээ тайлант онд 256.7 сая төгрөгөөр борлуулалтын и-баримтыг дутуу бүртгэсэнтэй холбоотой байна.													
Харилцагч байгууллагуудтай нийт 7 түрээслэгчээс 6 түрээслэгч гэрээний хугацаандаа төлбөрөө төлөөгүй хугацаа хэтрүүлсэн байхад 16.5 сая төгрөгийн алданги тооцоогүй байна.	1	0.0	-	-	-	-	1	0.0	-	-	-	-	-
Дүн	10	5,914.7	-	-	5	5,658.0	5	256.7	-	-	-	-	-

3.3. АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой 6,847.5 сая төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дэд өртөө хуваарилах байгууламжид үерийн ус зайлуулах, суваг байгуулах тендерт Монгол менежмент төв ХХК шалгарч, гэрээ байгуулж, гэрээт ажлыг хүлээлцсэн акт үйлдсэн боловч тендерийн ажлын даалгаварт тусгасан Хандгайд дэд станцад суурилуулах насос (тендерийн үнэ 2.0 сая төгрөг), Олимп дэд станцад суурилуулах насос (тендерийн үнэ 3 кв-ийн Q=45 м3 – 2.5 сая төгрөг, 4 кв-ийн Q=435 м3 – 2.2 сая төгрөг) суурилуулах ажлыг хийсэн эсэх нь тодорхойгүй байна.	1	6.8	-	-	1	6.8	-	-
Харуул хамгаалалтын үйлчилгээний УБЦТС/20240103074 дугаар тендерт шалгарсан Өлзий хишиг гранд ХХК нь ТӨХ-нд шаардсан "Дээрх ажилтнууд нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх шаардлагатай бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийг сүүлийн 3 сар тендерт оролцогч тасралтгүй төлсөн болохыг нотлох. НД7, НД8", "НДШ төлдөг ажилтнуудын тоог тендер шалгаруулалтын үнэлгээнд харгалзан үзэх болно." нотлох баримтыг ирүүлээгүй байна.	1	856.5	-	-	1	856.5	-	-
Үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг холбогдох журмын дагуу боловсруулахгүйгээр алдаатай боловсруулж, 22,113.5 сая төгрөгийн тендер зарласан нь оролцогчдоос гомдол, маргаан гарах, сонгон шалгаруулалтын үнэлгээ, дүгнэлт буруу гарах эрсдэлийг нэмэгдүүлж байна.	1	0.0	-	-	1	0.0	-	-
Тайланд онд зарласан 5,984.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтэд зээлийн мэдээллийн тухай хуулийн дагуу " тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг" ирүүлэхийг шаардаагүй байна.	1	5,984.3	-	-	1	5,984.3	-	-

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын алба нь 2024 онд төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалтуудыг хэрэгжүүлж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, сайжруулах чиглэлээр ажиллаж төлөвлөгөөт 12 шалгалтаар 97, гэнэтийн 4 шалгалтаар 18 нийт 115 асуудал илрүүлж, эдгээрийг шийдвэрлэх зорилгоор 110 зөвлөмж боловсруулан, мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгсөн. Гэвч холбогдох нэгжүүдэд зөвлөмжийг бүрэн хүргүүлээгүй, хэрэгжилтийн хяналт хангалтгүй байгааг анхаарах шаардлагатай байна. “Шалгалтын мөрөөр ажил зохион байгуулах” 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 1/2274 дугаар албан даалгаврын биелэлтийг 2 нэгжээс бусад нь хугацаандаа ирүүлээгүй тул шалгалтын үр дүн, хэрэгжилтийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Цаашид аудитын зөвлөмжийг холбогдох нэгжүүдэд бүрэн хүргэх, хэрэгжилтийн тайлагналтыг сайжруулах, хяналтын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр ажиллах шаардлагатай байна.	1	0.0	-	-	1	0.0	-	-
Дүн	5	6,847.5	-	-	5	6,847.5	-	-